

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2021-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО

Нийслэлийн Өмчийн харилцааных газарт нь 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд эдийн засгийн бодлогын хүрээнд нийслэлийн өмчийн хөрөнгийн зах зээлийн бодит үнэлгээг тогтоож, өмч ашиглалтыг эргэлтэд оруулахаар 4 арга хэмжээг төлөвлөн ажилласан.

3.1.1.1. Нийслэлийн хэмжээнд өмчийн бүртгэлийн бие даасан мэдээллийн санг бий болгоно:

Тус бодлогын баримт бичгийн хүрээнд 2024 оны 05 сарын 30-ны өдрөөс НЗДТГ-ын Мэдээлэл технологийн газрын Дэд бүтэц, техникийн хяналтын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг, гүйцэтгэгч “Ухаалаг шийдэл компани” ХК-н төлөөлөл, НӨХГ-ын ӨБМХ-ийн дарга болон мэргэжилтэн нарын бүрэлдэхүүнтэй ажил эхлэсэн. Систем хөгжүүлэлтийн ажил 4 үе шаттай хийгдэж байгаагаас эхлэлийн тайлан авах, дэд системийн шинжилгээ хийх төлөвлөгөөт ажлууд бүрэн дууссан. Систем нэвтрүүлэх ажлын 3 дугаар үе шатны хөрөнгийн хөдөлгөөний модулийн хөгжүүлэлт 45%-тай байна. Мөн систем, модуль хөгжүүлэлтийн талаар нийт албан хаагчдад танилцуулга, санал авах сургалтыг зохион байгуулсан.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын дундын сүлжээ ERP системд дэд цэсээр ашиглагдахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологийн газраас тус дэд системийг сервирт байршуулах зөвшөөрөл хүлээгдэж байна. Төсөл арга хэмжээний батлагдсан төлөвлөгөөний дагуу 67,5%-ын гүйцэтгэлтэй ажиллаж байна.



Зураг 1

Төсөл арга хэмжээний хүрээнд 2021-2024 онуудад хийгдсэн ажлууд он тус бүрээр дэлгэрэнгүй байдлаар танилцуулвал:

2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй хуулийн этгээдүүдээс НИТХ-ын тогтоолоор 2 хуулийн этгээдийг татан буулгаж, 2 хуулийн этгээдийн хөрөнгө хүлээлцэн татан буулгах бэлтгэл ажлыг ханган, татан буулгах тогтоолын төсөл өргөн барьсан.

1. Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК

Нийслэлийн удирдах ажилтнуудын 2024.04.01-ний өдрийн шуурхай зөвлөгөөнөөс тус компанийг татан буулгах ажлыг зохион байгуулах чиглэлийн дагуу НӨХГ-ын 2024.04.05-ны өдрийн 2/634 тоот албан бичгээр Компанийн тухай хуулийн дагуу татан буулгах ажлыг

Хувьцаа эзэмшигчдийн болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, зохион байгуулахыг мэдэгдсэн. Мөн тус компанийг татан буулгахтай холбоотой асуудлыг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024.03.06, 2024.04.18, 2024.04.23-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн, ТУЗ-ийн хурлаас татан буулгах тогтоолын төслийг хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн хуралд 2024.04.23-ний өдрийн 31 тоот албан бичгээр хүргүүлсэн. НИТХ-ын 61 дүгээр тогтоолоор 2024.04.30-ний өдрөөр “Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт” ХХК-ийг татан татан буулгахаар шийдвэрлэсэн.

2. “Бэлчээрийн менежмент хэрэгжүүлэх төслийн нэгж” ОНӨТҮГ

НЗДТГ-ын даргын 2024.05.09-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” А/92 дугаар тушаалаар “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгах бэлтгэл ажлыг хангах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажилласан. НЗД-ын 2024.05.28-ны өдрийн 01/3107 тоот албан бичгээр татан буулгах тогтоолын төсөл өргөн барьсан. НИТХ-ын 2024.06.18-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ-ыг татан буулгахаар шийдвэрлэсэн.

3. “Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо” ХК

“Улаанбаатар зүүн азийн наадам 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж дууссан тул татан буулгахаар НӨХГ-аас 2024.09.04-ний өдрийн 2/1527 дугаар албан бичгээр татан буулгах тогтоолын төсөл дээд шатны байгууллагад өргөн барьсан.

4. “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ

Үндсэн чиг үүрэг дуусгавар болж нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгад холбогдох байгууллагууд нүүн орсон тул тус үйлдвэрийн газрыг татан буулгахаар НӨХГ-аас 2024.09.04-ний өдрийн 2/1526 дугаар албан бичгээр татан буулгах тогтоолын төсөл дээд шатны байгууллагад өргөн барьсан.

3.1.1.3. Нийслэлийн өмчийг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрөх орлогыг нэмэгдүүлнэ:

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам”-ын дагуу нийслэлийн өмчийн илүүдэлтэй байр талбайг ашиглуулах түрээсийн гэрээг иргэн, хуулийн этгээд, эзэмшигч байгууллагуудтай байгуулан, нийслэлийн төсөвт батлагдсан хуваарийн дагуу орлого төвлөрүүлэн ажиллаж байна. Үүнд:

| № | Огноо | Төлөвлөгөө сая.төг | Гүйцэтгэл сая.төг | Хувь | (- илүү, +дутуу) |
|------------|--|-----------------------|----------------------|--------------|---------------------|
| 1 | 2021 оны түрээсийн орлого төвлөрүүлэлт | 2,075.4 | 2,349.9 | 100% | +274.5 |
| 2 | 2022 оны түрээсийн орлого төвлөрүүлэлт | 2,000.0 | 1,817.7 | 90,8% | -182.3 |
| 3 | 2023 оны түрээсийн орлого төвлөрүүлэлт | 1,800.0 | 1,632.3 | 90,1% | -167.7 |
| 4 | 2024 оны түрээсийн орлого төвлөрүүлэлт (3 дугаар улирлын байдлаар) | 1,960.0 | 1,851.8 | 94% | -108.2 |
| ДҮН | | 7,835.4 | 7,651.7 | 97,6% | - |

3.1.1.5. Нийслэл хотын хөгжлийг дэмжих, төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх санхүүгийн шинэ эх үүсвэрийг бий болгох зорилгоор нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоох ажлыг зохион байгуулна:

Тус бодлогын баримт бичгийн хүрээнд 2022 онд нийслэлийн өмчийн томоохон үл хөдлөх хөрөнгүүдийн зах зээлийн бодит үнэ цэнийг тогтоохоор хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалт явуулж "Мөнх Оргил Трейд" ХХК, "Прайсвотерхаус Күүперс Эдвайзори" ХХК-нуудаар нийт нийслэлийн өмчийн 24 хөрөнгөд үнэлгээ хийлгэсэн. Үнэлгээний тайланг дээд шатны байгууллагад танилцуулж, байгууллагын цахим хуудсанд нээлтэй байршуулан иргэн аж ахуй нэгж танилцах боломжоор хангасан. Үүнд:

1. НӨХГ-ын даргын 2021 оны А/581 дүгээр тушаалаар нийслэлийн өмчөөс 2022 онд хувьчлагдах барилга байгууламжийн хөрөнгийн үнэлгээ хийх зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдан НӨАУГ/202201001 тендерийн сонгон шалгаруулалтад "Мөнх Оргил Трейд" ХХК шалгарч гэрээ байгуулсан.

1. Хар үнэгний аж ахуйн хөрөнгө
2. Мал эмнэлэгийн лабораторын хөрөнгө
3. СБД-ийн Тамгын газрын өргөтгөлийн хөрөнгө
4. СБД-ийн Нэгдсэн эмнэлгийн хөрөнгө
5. 50 дугаар дэлгүүрийн өргөтгөлийн хөрөнгө
6. Монгол шуудангийн барилга 36-р салбар
7. Монгол шуудангийн барилга 44-р салбар
8. Монгол шуудангийн барилга 26-р салбар
9. Монгол шуудангийн барилга 46-р салбар
10. Халуун усны барилга ХУД-ын 16 хороо
11. Халуун усны барилга СБД-ын 15 хороо
12. Халуун усны барилга СБД-ын 16 хороо
13. Халуун усны барилга СБД-ын 4 хороо
14. Халуун усны барилга СХД-ын 25 хороо

2. НӨХГ-ын даргын 2022 оны А/218 дугаар тушаалаар үнэлгээний хороог шинэчлэн байгуулж, нийслэлийн өмчийн 10 барилга байгууламжид зах зээлийн үнэлгээ хийлгэх зөвлөх үйлчилгээний тендерийн сонгон шалгаруулалт явуулж, "Прайсвотерхаус Күүперс Эдвайзори" ХХК шалгаран 281,078,160.0 төгрөгийн төсөвт өртөг бүхий НХААГ/202204431 дугаартай гэрээ байгуулсан.

1. Гэрлэх ёслолын ордны барилга
2. Хүүхдийн ордны барилга
3. Соёлын төв өргөөний барилга
4. Нийслэлийн Төр захиргааны 2 дугаар байр, 1 хэсэг
5. Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр
6. Нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байр
7. Хүүхдийн урлан бүтээх төвийн барилга
8. ХУД-ийн ЗДТГ-ын /шүүхийн/ барилга
9. ХУД-ийн ЗДТГ-ын /татварын/ барилга
10. ХУД-ийн Соёлын ордны барилга

2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/711 дүгээр захирамжаар "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ыг татан буулгахаар шийдвэрлүүлж, нийслэлийн төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийн тоог 1-ээр буурууллаа.

Тус ажлын хүрээнд 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 2/1081 дүгээр албан бичгээр Булган аймгийн Татварын хэлтэст тус үйлдвэрийн газарт татварын шалгалт хийлгүүлэх хүсэлт хүргүүлсэн. Булган аймгийн Татварын хэлтсийн 2023.10.26-ны өдрийн 05/730 дугаар албан бичиг, “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ-аас ирүүлсэн 2023.10.20-ны өдрийн 0001/06 дугаар албан бичгүүдээр хариу ирсэн. Татан буугдаж байгаа үйлдвэрийн газрын санхүүгийн өр авлагын тайлан мэдээг судлаж, танилцсаны үндсэн дээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023.11.20-ны өдрийн 2/1433 дугаар албан бичгээр 2022 оноос 2023 оны хугацааны ажилчдын цалин, нийгмийн даатгалын өр, татварын өр, бусад өр нийт 93 сая төгрөгийн санхүүжилтийг 2024 оны төсөвт суулгуулах тухай хүсэлтийг хүргүүлсэн.

Нийслэлийн Нийслэл бие даасан мэдээллийн нэгдсэн сантай болох зорилгоор НЗД-ын 2023 оны А/1138 дугаар захирамжаар “Цахим Улаанбаатар” төслөөс 110 сая төгрөгөөр санхүүжүүлэх эрх шилжиж тендер зарласан ч НИТХ-ын 15-р тогтоолоор төсөвт өөрчлөлт орсон. 2023.11.24-ны өдөр нээх байсан тендерийг хүчингүй болсон.

3.1.1.2. Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат болон төрийн өмчит компанийн тоог бууруулна:

Тус бодлогын баримт бичгийн хүрээнд 2020-2024 оны хугацаанд нийслэлийн төсвөөс санхүүжиж байсан 4 хуулийн этгээдийг татан буулгаж, 3 орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг хаалттай хувьцаат компани болгон өөрчлөн байгуулсан байна. Мөн 2024 оны гуравдугаар улиралд багтаан 2 хуулийн этгээдийг татан буулгахаар ажиллаж байна.

Татан буулгасан хуулийн этгээд:

| № | Хуулийн этгээдийн нэр | Тогтоол шийдвэр |
|----|--|---------------------------------------|
| 1. | “Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ | НИТХТ-ийн 2021 оны 191 дүгээр тогтоол |
| 2. | “Үртсэн шахмал түлшний үйлдвэр” ОНӨААТҮГ | НИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоол |
| 3. | Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт ХХК | НИТХ-ын 2024 оны 61 дүгээр тогтоол |
| 4. | “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” ОНӨТҮГ | НИТХ-ын 2024 оны 87 дугаар тогтоол |

Өөрчлөн байгуулагдсан хуулийн этгээд:

| № | Хуулийн этгээдийн нэр | Өөрчлөгдсөн нэршил | Тогтоол шийдвэр |
|----|--|--|------------------------------------|
| 1. | “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар | “Багахангай үйлдвэрлэл, технологийн парк” хаалттай хувьцаат компани | НИТХ-ын 2024 оны 36 дугаар тогтоол |
| 2. | “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар | “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” хувьцаат компани | НИТХ-ын 2024 оны 37 дугаар тогтоол |
| 3. | Налайх Барилгын материалыг үйлдвэрлэл, технологийн парк орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар | “Налайх Барилгын материалыг үйлдвэрлэл, технологийн парк” хувьцаат компани | НИТХ-ын 2024 оны 38 дугаар тогтоол |

Татан буулгах тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн хуулийн этгээд:

| № | Хуулийн этгээдийн нэр | Өргөн мэдүүлсэн албан бичиг |
|----|---|---|
| 1. | “Улаанбаатар зүүн азийн наадам зохион байгуулах хороо” ХК | НӨХГ-аас 2024.09.04-ний өдрийн 2/1527 дугаар албан бичгээр татан буулгах тогтоолын төсөл дээд шатны байгууллагад өргөн барьсан. |
| 2. | “Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор | НӨХГ-аас 2024.09.04-ний өдрийн 2/1526 дугаар албан бичгээр татан буулгах тогтоолын төсөл дээд |

| | |
|--|--|
| барилгын ашиглалтын өмнөх захиргаа” ОНӨТҮГ | шатны байгууллагад өргөн барьсан. “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” хувьцаат компани |
|--|--|

Нийслэлийн болон 9 дүүргийн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газруудын тайлан балансыг хүлээн авч эдийн засгийн тооцоо судалгааг хийж ажилласан. Судалгааны үндсэн дээр “Улаанбаатар лифт” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг “Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар”-тай, “Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг “Хүнс хангамж төв” орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газартай, 4 үйлдвэрлэл технологийн паркыг харьяа яамдад шилжүүлэх эсвэл нэгтгэж нэгдсэн 1 захиргаатай болгох зэрэг саналыг боловсруулсан.

2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудаас НИТХ-ын тогтоолоор 1 хуулийн этгээдийг татан буулган, 1 хуулийн этгээдийг татан буулгахаар бэлтгэл ажил хийгдсэн. Үүнд:

- “Нийслэлийн нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийг хугацаанд нь чанартай, бүрэн хэрэгжүүлэх үүрэг бүхий Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа ОНӨТҮГ-ыг татан буулгасан.

- НИТХ-ын 2022.05.30-ны өдрийн 47 дугаар тогтоол, НЗД-ын 2022 оны А/887 дугаар захирамж, НӨХГ-ын даргын хөрөнгө хүлээлгэн өгөх удирдамжийн дагуу ын баланст бүртгэлтэй тоног төхөөрөмж, барилга байгууламжийг хөрөнгө хүлээлцэх актаар Булган аймгийн Засаг даргын Тамгын газарт хүлээлгэн өгсөн.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2022.02.15-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийн сангийн программ хангамжийн ажлын даалгаврыг боловсруулах ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд ажиллан бодлогын даалгаврын төсөлд хуулийн этгээдийн мэдээлэл, өмчийн бүртгэл, хөрөнгийн хөдөлгөөн, төрийн болон орон нутгийн өмч хувьчлал, төрийн өмчийн удирдлага зохицуулалттай холбоотой программ хангамжийн системд тусгах саналыг өгсөн.

Нийслэлийн өмчийн мэдээллийн санг Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлж буй “Хөрөнгийн удирдлагыг сайжруулснаар тогтвортой байдлыг дээшлүүлэх нь” төсөлтэй уялдуулан хэрэгжүүлэхээр холбогдох танилцуулгыг бэлтгэх, ажлын хэсгийн хуралд оролцож санал өгөх зэргээр манай байгууллага нь тус ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж санал өгөх үүрэгтэй бөгөөд гүйцэтгэл бүрэн хангагдсан.

2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ

“Өмчийн бүртгэлийн нэгдсэн систем” хийх ажлын даалгаврын тоймыг боловсруулан системийн хөгжүүлэлт хийдэг томоохон 5 компани болох “Ай Си Ти групп”, “Интерактив”, “Ухаалаг шийдэл”, “Ай Ти Зон”, “Новелсофт” компаниудад үнийн санал ирүүлэхийг хүсч 2021.08.27-ны өдрийн 3/1071-3/1075 тоот албан бичгүүдийг хүргүүлсэн. Албан бичиг хүргүүлсэн компаниудаас “Новелсофт” ХХК болон “Ай Ти Зон” ХХК үнийн санал ирүүлэх боломжгүйгээ мэдэгдсэн бол үлдсэн компаниудаас 286 саяас 1,086.2 сая төгрөгийн хооронд үнийн санал ирүүлсэн.

Компаниудаас ирсэн үнийн саналыг үндэслэн Нийслэлийн 2022 оны төсвийн төлөвлөгөөний саналд дээрх арга хэмжээг 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр 2022-2023 онд он дамжин хэрэгжүүлэхээр буюу 2022 онд 500,0 сая төгрөгийн санхүүжилт

шаардлагатай талаар санал хүргүүлсэн боловч нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээнд тусгагдаж батлагдаагүй болно.

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗАР